

МУИС-ийн дүрмийн 4.1.1, 4.1.2, БШУЯ-ны 2013.01.03-ны өдрийн 10/40 тоот албан бичгийг тус тус үндэслэн тушаах нь:

1. МУИС-ийн Удирдах зөвлөл дэх багш нарын төлөөллийг сонгох ажлыг зохион байгуулж явуулахыг ЗХШҮА-ы дарга /М.Отгонбаяр/ болон бүрэлдэхүүн сургуулиудын захирлуудад үүрэг болгосугай.
2. Удирдах зөвлөл дэх оюутны төлөөллийг сонгох ажлыг МУИСОХ Оюутны Конгрессийн тэргүүн МТС-ийн оюутан Г.Чойжамцад зөвшөөрсүгэй.
3. Сонгуулийг 2013 оны 01 дүгээр сарын 08-ны дотор багтаан явуулж дүнг ирүүлэхийг ЗХШҮА-ы дарга /М.Отгонбаяр/, МУИСОХОК-ийн тэргүүн /Г.Чойжамц/-д үүрэг болгосугай.
4. Сонгууль зохион байгуулах ажлын удирдамжийг хавсралтаар баталсугай.

МУИС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгч

А.Галтбаяр

**МУИС-ийн удирдах зөвлөл дэх багшийн төлөөлөл  
сонгох ажил явуулах удирдамж**

Сонгуулийг хоёр үе шаттай явуулна.

1. Бүрэлдэхүүн сургуулиудаас нэр дэвшүүлэх
2. МУИС-аас нэр дэвшүүлэх

**Эхний шат:** **Бүрэлдэхүүн сургуулийн багш нарын санал хураалт**

**Хугацаа:** Бүрэлдэхүүн сургуулийн багш нарын хурлыг 2013 оны 01 дүгээр сарын 08-ны дотор багтаан зохион байгуулна. Хуралд оролцогчдоос 3-5 багшийн бүрэлдэхүүнтэй комисс сонгож хурлыг удирдуулна.

**Бүрэлдэхүүн:** МУИС-ийн дүрмийн 4.1.1, 4.1.2 заалтын дагуу хуралд үндсэн болон зөвлөх, гэрээт багш, эрдэм шинжилгээний ажилтан нар /01 тушаалд нэр орсон/ оролцоно. /Сонгуульд цагийн багш орохгүй/

**Ирц:** Хурал багш нарын 2/3-оос доошгүй ирцтэй байж хүчинтэйд тооцогдоно.

**Нэр дэвшүүлэх:** Нэр дэвшигч Удирдах Зөвлөлд хэрхэн ажиллах талаараа товч танилцуулна.

**Дүн:** Нууц санал хураалтаар хамгийн олон санал авсан багшийг дараагийн шатны сонгуульд оруулна.

**Ирүүлэх материал:** ЗХШҮА-д 2013.01.08-ны өдрийн 17.00 цагт багтаан дараах материал ирүүлнэ. Үүнд:

1. Санал хураалтын хурлын тэмдэглэл
2. Санал хураалтын комиссын тогтоол
3. Санал хураалтад оролцох багш нарын нэрсийн жагсаалт

**Хоёр дахь шат:** **МУИС-ийн багш нарын санал хураалт**

Саналыг МУИС-ийн хичээлийн 1-р байранд 2013 оны 01 сарын 10-ны өдөр 10.00-17.00 цагт авна.

Нэр дэвшсэн 14 багшаас хамгийн олон санал авсан 5 багшийг МУИС-ийн Удирдах Зөвлөлийн гишүүнээр сонгогдсонд тооцно.

**Захиргаа, хяналт шинжилгээ, үнэлгээний алба**

**2013.01.07.**